



ХОВД АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 71

Ховд


Дэд хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол улсын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2015 оны 154 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Архи, тамхигүй-Ховдчууд” дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, жил тутмын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгаж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Баасандорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЭНХТӨР

Жаргалант сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
хуралдаанаар хэлэлцэх асуудал


2015.04.10-ны 09:00 цаг

№	Хэлэлцэх асуудал	Асуудалд оруулахыг зөвшөөрсөн албан тушаалтан	Асуудал оруулах албан тушаалтан	Хуралдаанаас гарах шийдвэр
1	Дэд хөтөлбөр батлах тухай (Архи, тамхигүй-Ховдчууд)	ИТХ-ын дарга	ЗДТГ-ын эрх зүйн ажилтан Б.Даваасүрэн	Тогтоол
2	Жаргалант суманд 2015 онд нийтээр тэмдэглэх ой, тэмдэглэлт өдөр, спорт урлагын арга хэмжээ, сургалт зөвлөгөөний нэгдсэн төлөвлөгөө батлах тухай	ИТХ-ын дарга	ЗДТГ-ын Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ц.Энх-Амгалан	Тогтоол
3	Төрийн дээд одон медалиар шагнуулах иргэдийн ажил байдлын тодорхойлолтыг хэлэлцэх	ИТХ-ын дарга	ИТХ-ын ажилтан Б.Батжаргал	Тогтоол

-----oOo-----

	байгууллагуудад сургалт сурталчилгаа дэс дараатайгаар зохион байгуулах		улиралд	туслалцааны төв, Цагдаагийн байгууллага, Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн	Засаг даргын Тамгын газар
12.	Архины хамааралтай болон архины хамаарлаас гарсан иргэдийн дунд явган аялал зохион байгуулан, архины хамаарлаас ангижирч амьдралын зөв хэвшилтэй болсон иргэдийн туршлага, зөвлөгөөг сурталчлан, яриа таниулга хийн тэмцээн зохион байгуулах	500.000 төгрөг	9 дүгээр сард	Цагдаагийн ОНХА-ны хошууч М.Оюунсүрэн ОНЦА Г.Тунгалаг Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ц.Энх-Амгалан Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн	Сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар
Нийт мөнгөн дүн		7.000.000 төгрөг			

----- 000 -----



“АРХИГҮЙ, ТАМХИГҮЙ-ХОВДЧУУД” ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ.ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага архидан согтуурсны улмаас хордох, архинд донтох өвчтэй болохоос гадна зүрхний титэм судасны өвчин, тархинд цус харвах, чихрийн шижин зэрэг 60 гаруй өвчин архидалттай ямар нэг хэмжээгээр холбоотой үүсч, даамжирч байгаагийн дотор элэгний хатуурал, улаан хоолой, элэгний хавдар, эпилепси болон осол гэмтэл, санаатайгаар хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулж байгаа тохиолдлын 20-30 хувь нь архидалтаас үүдэлтэй байна гэж тооцоолжээ.

Сумын хэмжээнд 2014 онд үйлдэгдсэн 357 гэмт хэргийн 99 буюу 27 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байх ба архидан согтуурсны улмаас 2014 онд нийт 3135 хүн эрүүлжигдэж, 7596 хүн захиргааны зөрчилд холбогджээ.

Дээрх иргэдийн ихэнхи нь ахуйн хүрээнд архидан согтуурсан байх нь гэр бүлийн хүчирхийллийн үндсэн шалтгаан болж иргэдийн тайван амьдрах боломжийг алдагдуулж, өрхийн орлого буурах, ядуурлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг болсоор байна.

Архидан согтуурах нь гэр бүл дэх хүчирхийлэл, гэр бүл салалт, ажил таслалт, сургууль завсардалт болон хүүхэд өсвөр үеийнхний архи ууж, тамхи татах, мансуурах хорт зуршилд автах шалтгааны нэг болж байна.

Мөн тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар зохих үр дүнд хүрч ажиллаж байгаа эсэх талаар хангалтгүй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын тамхидалтын талаархи судалгааг авсан боловч үнэн зөв бодитой мэдээлэл ирүүлэхгүй байгаа бөгөөд сургуулийн нийгмийн ажилтангууд архидан согтуурсан сурагчид эрүүлжигдсэн талаар доривтой арга хэмжээ авч ажиллахгүй байгаагаас ЕБС-ын сурагчдын согтууруулах ундаа хэрэглэх, түүнээс улбаалан гэмт хэрэг зөрчилд холбогдох, танхайрах явдал гарсаар байна.

Иймд ЕБС-ын Эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт архи, тамхины талаарх хичээлийг түлхүү оруулж, эрүүл мэндийн газрын мэргэжлийн хүнээр хүний биед учруулах хор уршгийн талаар хичээл заалгах, эрүүл, зөв, боловсон зан үйлийн дадал зуршлыг сурагчдад төлөвшүүлэх нэн шаардлага тулгараад байна.

Архи, тамхины хор хөнөөл, үүнээс үүдэн гарч буй гэмт хэрэг зөрчил хүний эрүүл мэнд нийгэмд учирч буй хор уршгийг багасгах, архины хамааралтай иргэдийг нийгэмшүүлэх, архинаас гаргах эмчилгээнд хамруулах, гэр бүл нийгэмд тустай иргэн болон төлөвшихөд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх, албан байгууллага үйлчилгээний орчин, нийтийн эзэмшлийн газрууд архигүй, тамхигүй тавлаг орчин бүрдүүлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд аж төрөх эрхийг хангах, амгалан тайван байдлыг хамгаалах зорилгоор энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХУГАЦАА

2.1.Хөтөлбөрийн зорилго

Иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн санал санаачлагыг дэмжин тэдгээрийн идэвхитэй оролцоонд түшиглэн архи тамхины хэрэглээг багасган соёлтой хэрэглээний хандлага төлөвшүүлэхэд дэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилт

2.2.1.Архины хамааралтай иргэдийн дэлгэрэнгүй судалгааг багуудаас гаргуулан, дүн шинжилгээ хийн, авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн ажиллах.

2.2.2.Архи, тамхинаас гарах чин хүсэлтэй иргэдэд туслах, нөлөөлөх ажлыг зохион байгуулах эрүүл мэндийн байгууллага болон сайн дурын бүлэгтэй хамтран, ажиллаж хөрөнгө санхүүд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх,

2.2.3.Архи, тамхи худалдаалах, түүгээр үйлчлэхгүй байх хэм хэмжээг зөрчсөн аж ахуй нэгж, байгууллагын үйлчилгээний зөвшөөрлийг хязгаарлах, хүчингүй болгох эрх зүйн арга хэрэгслийг бүрэн ашиглаж бодит ажил хэрэг болгох

2.2.4.ЕБС-ын сурагчид, оюутнуудад архи, тамхины зан үйлийг төлөвшүүлэх

2.2.5.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, гэр бүл, хамт олны архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг хариуцлагыг тодорхой болгон хамтын ажиллагааг сайжруулснаар дэмжлэг бүхий орчинг бүрдүүлнэ.

2.3.Хөтөлбөрийн хугацаа

2.3.1.Нэгдүгээр үе шат: 2015-2016 онд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт, төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх

2.3.2.Хоёрдугаар үе шат: 2016-2018 онд дэд хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийх

ГУРАВ.ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.Архи хэрэглэдэггүй хүмүүсийн туршлага, зөвлөгөөг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг тогтмолжуулах, тэдний оролцоотойгоор архидан

согтуурахаас сэргийлэх олон нийтийн байгууллага байгуулж, ажиллах үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжих

3.2.Сумын хэмжээнд байгаа архины хамааралтай иргэд, архаг архичдын дэлгэрэнгүй судалгааг баг тус бүрээр үнэн зөв гарган архи, тамхины хамаарлаас ангижрах хүсэлтэй иргэдийн нарийвчилсан бүртгэл хийх.

3.3.Архи, тамхины хор хөнөөл архидан согтуурахын хор уршиг, архи тамхины хамаарал бүхий иргэдийн хандлагыг өөрчлөх, эрүүл зөв амьдрах чиглэлийн сургалт лекц, яриа, таниулга, хэлэлцүүлэг сургалт сурталчилгааны ажлыг үр дүнтэй тогтмол зохион байгуулах

3.4.Аливаа баяр ёслол тэмдэглэлт өдрүүдийг архи, тамхигүй тэмдэглэх уриалга гарган, зорилт дэвшүүлэн ажиллах.

3.5.Сургалт эмчилгээнд хамрагдан архины хамаарлаас гарсан иргэдийг нийгэмшүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, тэдний ар гэр амьдрал ахуйд бодитоор туслан дэмжих, үүнтэй холбоотой төсөв санхүүг шийдвэрлүүлэх

ДӨРӨВ.ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.1.Сумын ИТХ, Засаг дарга

4.1.1.Иргэдийн оролцоонд түшиглэн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд баяр, ёслол, тэмдэглэлт үйл явдлыг архигүй, тамхигүй орчинд тэмдэглэн, тодорхой зорилт дэвшүүлэн ажиллах

4.1.2.Архи, тамхи хэрэглэдэггүй, амьдралын зөв хэвшилтэй болон архины хамаарлаас ангижирсан хүмүүсийн туршлага, зөвлөгөөг сурталчлах, тэдний оролцоотойгоор архидан согтуурахаас болон тамхины хор хөнөөлөөс сэргийлэх сайн дурын бүлэг холбоо байгуулж ажиллах үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжин ажиллах

4.1.3.Архинд донтох өвчтэй иргэнийг сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулан, архины хамаарлаас гарах эмчилгээ хийлгэсэн хүний ахуй амьдралд туслах

4.1.4.Баг, хамт олны ажлыг дүгнэхдээ архидан согтуурахаас сэргийлэх, тамхины хяналтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж хийсэн ажлын бодит үр дүнг харгалзан үздэг байх.

4.1.5.Сум хөгжүүлэх сангаас олгож буй хөнгөлттэй зээл, нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд архины хамаарлаас ангижрах сургалт, эмчилгээнд хамрагдсан иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах.

4.1.6.Тамхи худалдаалах түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгжид зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт шаардлагыг өндөржүүлэн, хуулийн хэрэгжилийг ханган ажиллах

4.1.7.Согтууруулах ундаа, тамхины худалдаа үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, дэлгүүр, зоогийн газар, зэрэг бусад байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран байнгын хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллах

4.1.8.Архи, тамхины сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах үр дүнг тооцох

4.1.9.Өсвөр залуу үеийнхний дунд архи тамхины хор хөнөөлийн талаар сургалт сурталчилгааны ажлыг түлхүү зохион байгуулж ажиллах

4.1.10.Орон гэргүй тэнэмэл амьдралтай, архины хамаарлаас гарах сургалт, албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийг нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, тусламж үйлчилгээнд хамруулах.

4.2.Багийн Иргэдийн Нийтийн хурал, Багийн Засаг дарга

4.2.1.Дэд хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн тухайн нутаг дэвсгэрийн онцлог, тулгамдсан асуудалд тулгуурласан, төлөвлөгөө боловсруулан баталж, төлөвлөгөөний дагуу ажлуудыг доривтой зохион байгуулж ажиллах

4.2.2.Тухайн багийн нутаг дэвсгэрт байрлах согтууруулах ундаа, тамхи худалддаг /үйлчилдэг/ аж ахуй нэгж, дэлгүүр, зоогийн газар, зэрэг бусад байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж, хүүхэд, залуучууд, боловсролын байгууллагын орчинд согтууруулах ундааг худалдахгүй /үйлчлэхгүй/ байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4.2.3.Багийнхаа иргэдийн дунд аливаа баяр ёслолын үйл ажиллагааг архи, тамхигүй, соёлтой, зөв боловсон тэмдэглэн өнгөрүүлэх талаар уриалга гарган ажиллах

4.2.4.Архины асуудалтай, архинд хамааралтай иргэнгүй баг, байгууллага, аж ахуй нэгж болгох, иргэн бүрт хууль эрх зүйн актуудыг болон тэр талаар гаргасан сайн үр дүнтэй арга ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, иргэн бүрийг гэмт хэрэгт өртдөггүй болгон хүмүүжүүлэн төлөвшүүлэхэд идэвхитэй үйл ажиллагаа явуулах.

4.3.Хэвлэл мэдээллийн байгууллага

4.3.1.Архидан согтуурснаас нийгэм, эдийн засаг, хувь хүний ёс зүй, бие, сэтгэцэд учрах хор уршгийн талаар нийт хүн ам, ялангуяа хүүхэд өсвөр үеийнхэнд тодорхой дэс дараатай мэдлэг, хандлага, зөв зан үйлийг эзэмшүүлэхэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгааг нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөртөө тусгах, цагийг нэмэгдүүлэх, захиалагчдад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх;

4.3.2.Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиож буй ажлын ололт, дутагдлыг тухай бүр нийтэд сурталчилж байх.

4.4. Иргэн, гэр бүл, олон нийт

4.4.1.Иргэн бүр архины хор уршгийн талаар зохих мэдлэгтэй болж үр хүүхэд, гэр бүлийнхэндээ тайлбарлан таниулах, хүүхэд, залуучуудыг багаас нь эрүүл амьдрах ухаанд сургах;

4.4.2.Архины асуудалтай хүн, түүний гэр бүлд мэргэжлийн байгууллага, хүмүүсээс хууль эрх зүй, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, олон нийтийн зүгээс энэ чиглэлээр туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

4.4.3.Насанд хүрэгчид, эцэг, эхчүүд согтууруулах ундааг зүй зохистой хэрэглэх уламжлалт зан үйлээ сэргээн хэвшүүлэх, хүүхэд, залуучуудад зөв үлгэр дууриалал үзүүлэх.

ТАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

5.1.Дэд хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

5.1.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хариуцан удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хөтөлбөр хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гарган, санхүүжилтийн асуудлыг орон нутгийн төсөвт тусгуулан зарцуулах.

5.1.2.Дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх ажлыг сумын Засаг даргын Тамгын газар хариуцна. Хагас бүтэн жилээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс болон сумын ИТХ-ын Тэргүүлэгчидэд хөтөлбөрийн тайлан мэдээг мэдээллэх.

5.2.Дэд хөтөлбөрийн санхүүжилт

5.2.1.Орон нутгийн төсвөөс

5.2.2.Бусад төсөл арга хэмжээ

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ, ТАЙЛАГНАХ

6.1.Хүрэх үр дүн

6.1.1.Архины хамааралтай иргэдийн тоо буурч, архидан согтуурах явдал, архинаас үйлдэлтэй гэмт хэрэг, зөрчлийн тоо багасна.

6.1.2.Сумын хэмжээнд архины хамааралтай иргэдийн дэлгэрэнгүй судалгаатай болсон байна.

6.1.3.Архины хамаарлаас ангижрах сургалт, арга хэмжээ, эмчилгээнд хамрагдах иргэдийн оролцоо сайжирч, архины хор хөнөөлийн талаар иргэдийн ойлголт сайжирна.

6.2.Тайлагнах дүгнэх

6.2.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллагууд хийж хэрэгжүүлсэн ажил, хүрсэн үр дүнгийн талаарх мэдээллийг хагас бүтэн жилээр сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлэх.

Жаргалант сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
Хуралдааны 2015 оны 04 дүгээр
сарын 10 -ны өдрийн ... дугаар
тогтоолын 2-р хавсралт

“АРХИГҮЙ, ТАМХИГҮЙ- ХОВДЧУУД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
2015 ОНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийж хэрэгжүүлэх ажил	Төсөв	Хугацаа	Хариуцах эзэн	Хяналт тавих эзэн
1.	Жаргалант сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр “Архигүй, тамхигүй Ховдчууд” дэд хөтөлбөрийг хэлэлцүүлэн төсөв батлуулах.	-	1 дүгээр улиралд	Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ц.Энх-Амгалан Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн	Засаг даргын Тамгын газрын дарга
2.	Байгууллагын дотоод журамд архигүй тамхигүй орчин бүрдүүлэх, аливаа тэмдэглэлт өдөр, баярын арга хэмжээг архигүй тэмдэглэх талаар заалт тусган бодитойгоор хэрэгжүүлж ажиллах.	-	1 дүгээр улиралд	Эрх зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн	Засаг даргын Тамгын газрын дарга
3.	Сумын хэмжээнд архинд донтох өвчтэй, архины хамааралтай иргэдийн судалгааг баг тус бүрээр үнэн зөв гаргах.	-	1 дүгээр улиралд	Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ц.Энх-Амгалан Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн	Засаг даргын Тамгын газрын дарга
4.	Төсөл хөтөлбөр арга хэмжээний хүрээнд 1 иргэнийг	Гэр 1.500.000, хашаа 1.900.000	Жилийн турш	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	ИТХ, ИТХ-ын

	сонгон авч, архины хамаарлаас бүрэн гаргаж, тухай иргэнийг орон гэр, хашаатай болгон цаашид амьдрах итгэл үнэмшил, урам зоригийг бий болгох.	бусад зардал 900.000 нийт 4.300.000		Ц.Энх-Амгалан Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн	Тэргүүлэгч С.Даваасамбуу Засаг даргын Тамгын газрын дарга
5.	Архи тамхины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршигын талаар ЕБС-дад лекц, яриа таниулга хийн, боршуур гарын авлага тараан, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах	бичгийн цаас 90000 төг шатахуун: 50л*2090=104500, анонас 100.000 бусад 60.000 нийт 394500	4 дүгээр улиралд	Цагдаагийн ОНХА-ны хошууч М.Оюунсүрэн ЕБС-ын нийгмийн ажилтангууд Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ц.Энх-Амгалан Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн	Засаг даргын Тамгын газрын дарга
6.	Согтууруулах ундаа тамхины худалдаа үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй иргэн, аж ахуй нэгжид мэргэжлийн байгууллагуудтай хамтарч тогтмол хяналт шалгалт хийх.	шатахууны мөнгө 6 удаагийн явалт, нэг удаагийн явалтанд 20 л шатахуун зарцуулна. нийт 250800	2 сард 1 удаа	Мал амьтан, хорио цээр чанарын хяналтын улсын байцаагч Т.Цагаанхишиг Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Нямчулуун Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн, ОНЦА Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ц.Энх-Амгалан хөдөлмөр эрхлэлтийг хариуцсан мэргэжилтэн Б.Энхзаяа Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн	Засаг даргын Тамгын газрын дарга
7.	Албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийг төсөл хөтөлбөрийн хүрээнд сургаж мэргэшүүлэх, ажлын байраар хангах, хөдөлмөрийн зохицуулалт хийх	-	Жилийн турш		Засаг даргын Тамгын газрын дарга
8.	Архины хамаарлаас ангижирч	3 телевиз 150.000	Жилийн	Эрх зүй, дотоод ажил	Засаг даргын

	<p>амьдралын зөв хэвшилтэй болсон иргэдийн туршлага, зөвлөгөөг сурталчлан, тэдний оролцоотойгоор архидаан согтуурах, тамхины хор хөнөөлөөс сэргийлэх тухай телевизийн сайн дурын нэвтрүүлэг хийх, Иргэдэд чиглэсэн архи тамхины хор хөнөөлийн талаарх мэдээ мэдээллийг телевизийн нэвтрүүлгээр байнга нэвтрүүлэх</p>	<p>сонин 50.000 нийт 200.000</p>	<p>турш</p>	<p>хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн</p>	<p>Тамгын газрын дарга</p>
9.	<p>Ховд хотын нийт Оюутан залуучуудын дунд Архи тамхины хор хөнөөл бидний эргэн тойронд” сэдэвт илтгэлийн уралдаан зохион байгуулах, Мөн лекц, яриа таниулга хийх</p>	<p>Шагнал: эхний 3 байр өргөмжлөл 45000 төг, мөнгөн шагнал: I- байр 100.000, II-байр 80.000 III-50.000 телевизийн хөлс 80.000 НИЙТ:355.000</p>	<p>4 дүгээр сард</p>	<p>Цагдаагийн ОНХА-ны хошууч М.Оюунсүрэн ОНЦА ажилтан Г.Тунгалаг Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ц.Энх-Амгалан Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн</p>	<p>Засаг даргын Тамгын газрын дарга</p>
10.	<p>Архи тамхины хор уршигийн талаар иргэдэд нээлттэй өдөр зохион байгуулах. Архигүй орчныг бүрдүүлэх талаар эерэг хандлага, төлөвлөлийг бий болгох зорилготой.</p>	<p>1.000.000</p>	<p>2 дугаар улиралд</p>	<p>Хууль зүйн хэлтсийн эрх зүйн туслалцааны төв, Цагдаагийн байгууллага, багийн Засаг дарга Нийгмийн ажилтангууд, Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэн ОНЦА Г.Тунгалаг</p>	<p>Сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар</p>
11.	<p>Төрийн болон төрийн бус</p>	<p>-</p>	<p>2 дугаар</p>	<p>Хууль зүйн хэлтсийн эрх зүйн</p>	<p>Сумын ИТХ,</p>



ХОВД АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 72

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол Улсын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Жаргалант суманд 2015 онд нийтээр тэмдэглэх ой, тэмдэглэлт өдөр, спорт урлаг, сургалт зөвөлгөөний арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, зохион байгуулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын ЗДТГ-ын дарга /Д.Ариунбилэг/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Ажлын албаны дарга /П.Оюунтунгалаг/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЭНХТӨР

Жаргалант сумын ИТХ-ын Төргүүлэгчдийн
Хуралдааны 2015 оны 10 дугаар сарын
10-ний өдрийн 2 тогтоолын хавсралт

ЖАРГАЛАНТ СУМАНД 2015 ОНД НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ ОЙ, ТЭМДЭГЛЭЛТ ӨДӨР,
СПОРТ УРЛАГ, СУРГАЛТ ЗӨВӨЛГӨӨНИЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага
		Арга хэмжээ	Хүрэх түвшин		
1	Цагаан сарын хүндэтгэлийн арга хэмжээ	А.Ажил үйлсээрээ манлайлан тэргүүлэн ажилласан сумын 9 алдартан аваргуудын материалыг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шалгаруулах /тусгай хөтөлбөр/	А.Уламжлал болон хэвшиж оны шилдэг манлайлагч нарыг тодруулсан байна.	01-02 дугаар сард	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
		Б.Харъяалалгүй ахмад настаны судалгааг гаргаж нийгэм халамж үйлчилгээний хэлтэст хүргүүлэн гарын бэлгэнд хамруулах	Б.Ажиллаж байсан албан газар нь татан буугдсан дампуурсан байгууллагуудад ажиллаж байсан ахмад настангууд судалгаа үнэн зөв гарч гарын бэлгэнд хамрагдсан байна.		
		В.Байгууллагаас өндөр настаны тэтгэвэрт гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх	В.Амьжиргааны түвшин доогуур орлоготой өрхүүдэд дэмжлэг тусалцаа хүртсэн байна.	01-02 дугаар сард	Нийгмийн бодлогын мэргэжилтэн Багийн Нийгмийн ажилтан
	Г.Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой зарим өрхүүдийн хүүхдүүдэд				

	"Багшийн авьяас" спортын наадам зохион байгуулах	цэцэрлэгийн багш нарын дунд гар бөмбөг, ширээний теннис, сагсан бөмбөг, шатар, даам, орс таталтын тэмцээнийг удирдамжийн дагуу зохион байгуулах Б. Багш нарын тохиолдуулан ажил үйлсээрээ манлайлан ажилласан тэргүүний багш нарыг сумын Засаг даргын нэрэмжит шагналаар шагнуулах	оролцоо нэмэгдэнэ. Б. Ажлын чанар, бүтээмж сайжирна	
10	Ховд хот үүсгэн байгуулагдсаны 330 жилийн ой сумын баяр наадам зохион байгуулах	А.Тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах	А. Ой зохион байгуулагдсан байна.	Ажлын хэсэг 07 дугаар сард
11	Залуучуудын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	А.залуу гэр бүлийн дунд амьдрах арга ухааны лекц уншуулах Б.залуучуудын дунд спорт урлагийн арга хэмжээг зохион байгуулах	А.Залуучуудын идэвхи оролцоо нэмэгдсэн байна.	Залуучуудын холбоо 08 сард
12	Ахмадын баяр тэмдэглэх	А.Ахмадын өдөр, ахмадын баярыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах А.Харш сүлд модны наадамд нийгмийн халамжийн зорилготой бүлгийн хүүхдүүдийг хамруулах /Бүтэн өнчин/ Б.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн шинэ жилийн наадмыг холбогдох газартай хамтран байгуулж санхүүгийн дэмжлэг үзүүлэх	А.Ахмадууд баярын үйл ажиллагаанд оролцсон байна. Хүүхдүүд баярын үйл ажиллагаанд оролцсон байна.	Ажлын хэсэг 10 дугаар сард Ажлын хэсэг 12 сард
14	Төрийн албан хаагчдын тэмдэглэлт өдрийг зохион байгуулах	А.Өдрүүдийг тохиолдуулан спорт, танин мэдэхүйн уралдаан тэмцээнийг зохион байгуулах Сургалт зөвөлгөөн, соёл урлагийн арга хэмжээ	А.Уралдаан тэмцээн зохион байгуулагдаж, идэхт оролцоо сайжирсан байна.	Мэргэжилтэнгүүд Жилдээ
1	Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтанд мэргэжилтэнгүүдээс хамруулах	А. Сургалт зохион байгуулагдсан үед мэргэжилтэнгүүдээс хамруулах	А.АЗ сертификатай иргэдийн нэмэгдэж үнэлгээний хороонд оролцогчдын тоо нэмэгдэнэ	О. Буяндэлгэр жилдээ
2	Шилэн дасны тухай хуулиар сургалт зохион байгуулах			
3	Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд олон нийтийн оролцоотой хяналт тавих журмын хэрэгжилт, цаашид	Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавих журмын түүний хэрэгжилтийн	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалт.	О. Буяндэлгэр 1,2 –р улиралд

анхаарах асуудлын талаар гурван талт түншлэлийн хорооны гишүүд болон иргэдэд сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах	асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулна.	хөтөлбөр, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн чанар сайжирна.		
4 Сумын худалдан авах ажиллагаанд оролцогч олон нийтийн оролцоотой иргэдийн бүлгүүдэд тендерийн баримт бичиг боловсруулах аргачлалын талаар сургалт зохион байгуулах.	Суманд бүртгэлтэй иргэдийн бүлгүүд болон иргэдийн бүлэг байгуулан худалдан авах ажиллагаанд оролцох иргэдэд тендерийн баримт бичиг боловсруулах аргачлалын сургалт зохион байгуулна.	Тендерт оролцогч иргэдийн бүлгүүдийн худалдан авах ажиллагааны талаарх мэдлэг дээшилж тендерийн баримт бичиг боловсруулах чадвар нэмэгдэнэ.	2-р улиралд.	О.Буяндэлгэр
5 Төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулах, ур чадварыг нэмэгдүүлэх сургалт зөвөлгөөн хэлэлцүүлэг зохион байгуулах	Салбар чиглэлийн дагуу сургалтанд хамруулна Ажилчдад монгол бичиг, англи хэлний сургалтыг дотоод нөөц боломжоо ашиглан зохион байгуулна	Ажлын ур чадвар сайжирна өөрийн салбарын сүүлийн үеийн мэдээллээр хангагдана	жилдээ	Д.Ариунбилэг
6 Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах	Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ард иргэдэд нээлттэй хаалганы өдөрлөгийг баг тус бүр зохион байгуулах	Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг сурталчилснаар газар зохион байгуулалт сайжирна.	Жилдээ	Газрын мэргэжилтэнүүд
7 Малчин тариаланчдын зөвөлгөөн зохион байгуулах	Жаргалант сумын малчид болон газар тариалан эрхлэгчдийн дунд төмс, хүнсний ногоог дахин боловсруулах, бордооны зүй зохистой хэрэглээ, ургамал хамгаалал, хорио цээр чанарын хяналт, төрөөс газар тариалан, мал аж ахуйн чиглэлээр баримталж буй бодлого чиглэл сэдвээр сургалт явуулж, тэдний санал хүсэлтийг сонсож ажиллах	Малчид тариаланчид мэдээ, мэдээлэл гарын авлагаар хангагдана. Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилт сайжирна.	4 сард	Мал эмнэлэг, уржлийн тасаг
8 ЕБС-ийн ЭКО клубын сурагчид болон иргэдэд орчны бохирдолт талаар сургалт зохион байгуулах	ЕБС-ийн эко клубуудын сурагчидын дунд танин мэдэхүйн явган аялал зохион байгуулж, орчны бохирдол үүсэх гол шалтгаан түүнийг багасгах арга замын талаар мэдээлэл өгч, тэднээс гарах санал санаачилгыг дэмжин ажиллах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд орчны бохирдлыг бууруулах, хяналт тавих, ажилд хамтран ажиллах талаар	Орчны бохирдлын хэмжээ тодорхой хувиар буурч иргэд орчны бохирдол, эрүүл ахуйн талаар мэдлэг мэдээлэлтэй болно.	III улиралд	Б.Нямчулуун Б.Баяржавхлан Э.Гансүх

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Магсаржав багийн 52,62,72 айлын орон сууцны хорооллын дунд тоглоомын талбай шинэчлэх" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга

Б.Батсүх / Б.Д.Очирсүх /

Үнэлгээний хорооны гишүүд

.....
.....

Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга

Б.Буянзүр / Б.Д.Очирсүх /
О.О.О

2. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хороо *Б.Батсүх*.....-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.АРИУНБИЛЭГ

	төсөл хөтөлбөрийн байгууллага, ОУБайгууллага хувь хүмүүстэй хамтран дэмжлэг үзүүлэх				
2	Сумын буянтай ээж шалгаруулах хүндэтгэлийн арга хэмжээ	<p>А. Буянтай ээж шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлж, багуудад журмыг хүргүүлэх</p> <p>Б. Журмын дагуу ирсэн ээжүүдийн материалыг засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх</p>	А. Журам батлагдаж хэрэгжинэ.	03 дугаар сард	Нийгмийн бодлогын мэргэжилтэн Багийн Нийгмийн ажилтан Ажлын хэсэг
3	Дэлхийн усны өдөр тэмдэглэх	А.Багуудын иргэдийн дунд байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах сэтгэлзүйг нь нэмэгдүүлэх зорилгоор “Дэвжээ” тэмцээн зохион байгуулах	Иргэд эх байгаль дэлхий ус хайрлан хамгаалах сэтгэлзүйн нэмэгдэж Усны зүй зохисгүй хэрэглээ буурна.	3 дугаар сарын 22 өдөр	Сумын байгаль орчны тасаг, багийн Засаг дарга нар
4	Наурыз баярыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	А. Казак иргэдийн дунд хотын Захирагчийн нэрэмжит гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулах Б.Харъяалалгүй ахмад настаны судалгааг гаргаж, нийгэм халамж үйлчилгээний хэлтэст хүргүүлэн гарын бэлгэнд хамруулах	А. Уламжлал болон зохион байгуулагдаж иргэдийн оролцоо нэмэгдэнэ. Б. Судалгаа үнэн зөв гарч гарын бэлгэнд хамрагдсан байна	3 дугаар сарын 22 өдөр	Ажлын хэсэг
5	Нийгмийн ажилтаны өдөр зохион байгуулах	А. Терийн болон терийн бус байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтангуудын гэр бүлийн дунд “Нэгэн дээвэр дор” танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээн зохион байгуулах	А. Танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион байгуулагдсан байна Б. Хүмүүнлэгийн ажил зохион байгуулагдсан байна	03 дугаар сард	Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ажлын хэсэг

		<p>Б."Сайн үйлс сэтгэлийн дэм" хүмүүнлэгийн ажил зохион байгуулах</p> <p>А.Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх асран хамгаалагч нарын дунд гар бөмбөг, танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион байгуулах</p> <p>Б. Эцэг эх асран хамгаалагч нарын дунд тэдэнд тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг ярилцлага зохион байгуулах</p> <p>В. Хишиг өдөр зохион байгуулах /ХБХ-ийг ХоИС-ийн нийгмийн ажилтаны ангийн оюутан нартай хамтран ажиллах/</p>	<p>А. Иргэдийн оролцоо нэмэгдсэн байна.</p> <p>Б. Тулгамдаж буй асуудал нь тодорхойлогдсон байна.</p> <p>В. Эцэг эх асран хамгаалагч нар нь зав чөлөөтэй болж өөрийн хувийн ажлаа амжуулна</p>	<p>05 дугаар сард</p>	<p>Нийгмийн бодлогын мэргэжилтэн Багийн нийгмийн ажилтан нар Ажлын хэсэг</p>
<p>6</p> <p>Эрүүл агаар эм өдөрлөг зохион байгуулах</p>	<p>А. Залуу гэр бүлийн дунд "Амьдрах арга ухаан" лекц уншуулах</p> <p>Б. Байгууллагын ажилчдын гэр бүлийн дунд танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион байгуулах</p> <p>А.Тусгай хөтөлбөрөөр холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах</p> <p>Б.Эхийн алдар I,II одонгоор шагнагдах эхчүүдэд зар хүргэж хүндэтгэлийн үйл ажиллагаанд нь бүрэн хамруулах</p>	<p>А. Амьдрах арга ухаанд суралцана.</p> <p>Б.Гэр бүлийн оролцоо идэвх нэмэгдэнэ.</p> <p>А.Баярын үйл ажиллагааг зохион байгуулагдсан байна.</p> <p>Б. Эхийн алдар I,II одонгоор шагнагдах эхчүүд одонгоо баярын өдрөөр авна.</p>	<p>05 дугаар сард</p>	<p>Ажлын хэсэг</p>	
<p>7</p> <p>ОУ-ын "Гэр бүлийн баяр"ын өдрийг зохион байгуулах</p>	<p>8</p> <p>Эх үрсийн баяр</p>		<p>06 дугаар сард</p>	<p>Ажлын хэсэг</p>	

		<p>А. Ажлын хэсэг байгуулагдан ЕБС, цэцэрлэгийн багш нарын дунд гар бөмбөг, ширээний теннис, сагсан бөмбөг, шатар, даам, олс таталтын тэмцээнийг удирдамжийн дагуу зохион байгуулах</p> <p>Б. Багш нарын тохиолдуулан ажил үйлсээрээ манлайлан ажилласан тэргүүний багш нарыг сумын Засаг даргын нэрэмжит шагналаар шагнуулах</p> <p>В. Нийтийн цэнгээнт бүжгийн аварга шалгаруулах</p>	<p>А. Багш нарын идэвхи, оролцоо нэмэгдэнэ.</p> <p>Б. Ажлын чанар, бүтээмж сайжирна</p>	10 дугаар сард	Ажлын хэсэг
9	Хотын Захирагчийн нэрэмжит "Багшийн авьяас" спортын наадам зохион байгуулах	<p>А. Тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах</p>	А. Ой зохион байгуулагдсан байна.	07 дугаар сард	Ажлын хэсэг
10	Ховд хот үүсгэн байгуулагдсаны 330 жилийн ой сумын баяр наадам зохион байгуулах	<p>А. залуучуудын дунд спорт урлагийн арга хэмжээг тусгай хөтөлбөр төлөвлөгөөний пагуу гаргах зохион байгуулах</p> <p>Б. "Жаргалант сум залуу гэр бүл" групп нээх</p>	А. Залуучуудын идэвхи оролцоо нэмэгдсэн байна.	08 сард	Залуучуудын холбоо
11	Залуучуудын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	<p>А. Ахмадын өдөр, ахмадын баярыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах</p> <p>А. Харш сүлд модны наадамд нийгмийн халамжийн зорилтот бүлгийн хүүхдүүдийг хамруулах /Бүтэн өнчин/</p>	А. Ахмадууд баярын үйл ажиллагаанд оролцсон байна.	10 дугаар сард	Ажлын хэсэг
12	Ахмадын баяр тэмдэглэх	<p>А. Харш сүлд модны наадамд нийгмийн халамжийн зорилтот бүлгийн хүүхдүүдийг хамруулах /Бүтэн өнчин/</p>	Хүүхдүүд баярын үйл ажиллагаанд оролцсон байна.	12 сард	Ажлын хэсэг
13	Шинэ жил				

	Төрийн албан хаагчдын тэмдэглэлт өдрийг зохион байгуулах	Б.хөгжлийн хүүхдүүдийн наадмыг хамтран дэмжлэг үзүүлэх	А.Уралдаан тэмцээн зохион байгуулагдаж, идэхт оролцоо сайжирсан байна.	Жилдээ	Мэргэжилтэнгү үд
Сургалт зөвөлгөөн, соёл урлагийн арга хэмжээ					
14	Худалдан авгах АЗ сертификатын сургалтанд мэргэжилтэнгүүдээс хамруулах	А. Сургалт байгуулагдсан мэргэжилтэнгүүдээс хамруулах	А.АЗ сертификаттай иргэдийн нэмэгдэж үнэлгээний хороонд оролцогчдын тоо нэмэгдэнэ	жилдээ	О.Буяндэлгэр
3	Худалдан авгах ажиллагааны хэрэгжилтэнд олон нийтийн оролцоотой хяналт тавих журмын хэрэгжилт, цаашид анхаарах асуудлын талаар гурван талт түншлэлийн хорооны гишүүд болон иргэдэд сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах	Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавих журам, түүний хэрэгжилтийн асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулна.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн чанар сайжирна.	1,2 –р улиралд.	О.Буяндэлгэр
4	Сумын худалдан авгах ажиллагаанд оролцогч олон нийтийн оролцоотой иргэдийн бүлгүүдэд тендерийн баримт бичиг боловсруулах талаар	Суманд бүртгэлтэй иргэдийн бүлгүүд болон иргэдийн бүлэг байгуулан худалдан авах ажиллагаанд оролцох иргэдэд тендерийн бичиг баримт боловсруулах аргачлалын сургалт зохион байгуулна.	Тендерт оролцогч иргэдийн бүлгүүдийн худалдан авах ажиллагааны талаарх мэдлэг дээшилж тендерийн баримт бичиг боловсруулах чадвар нэмэгдэнэ.	2-р улиралд.	О.Буяндэлгэр

	сургалт зохион байгуулах.	Төрийн хаагчдын бүтээмжийг сайжруулах, чадварыг нэмэгдүүлэх сургалт зөвөлгөөн хэлэлцүүлэг зохион байгуулах	Салбар чиглэлийн дагуу сургалтанд хамруулна Ажилчдад монголт бичиг, англи хэлний сургалтыг дотоод нөөц боломжоо ашиглан зохион байгуулна	Ажлын үр чадвар сайжирна өөрийн салбарын сүүлийн үеийн мэдээллээр хангагдана	жилдээ	Д.Ариунбилэг
5	Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах	Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ард иргэдэд нээлттэй хаалганы өдөрлөгийг баг тус бүр зохион байгуулах	Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ард иргэдэд нээлттэй хаалганы өдөрлөгийг баг тус бүр зохион байгуулах	Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг сурталчилснаар газар зохион байгуулалт сайжирна.	Жилдээ	Газрын мэргэжилтэнгүү Д
6	Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах	Жаргалант сумын малчид болон газар тариалан эрхлэгчдийн дунд төмс, хүнсний ногоог дахин боловсруулах, бордооны зүй зохистой хэрэглээ, ургамал хамгаалал, хорио цээр чанарын хяналт, төрөөс газар тариалан, мал аж ахуйн чиглэлээр баримталж буй бодлого чиглэл сэдвээр сургалт явуулж, тэдний санал хүсэлтийг сонсож ажиллах	Жаргалант сумын малчид болон газар тариалан эрхлэгчдийн дунд төмс, хүнсний ногоог дахин боловсруулах, бордооны зүй зохистой хэрэглээ, ургамал хамгаалал, хорио цээр чанарын хяналт, төрөөс газар тариалан, мал аж ахуйн чиглэлээр баримталж буй бодлого чиглэл сэдвээр сургалт явуулж, тэдний санал хүсэлтийг сонсож ажиллах	Малчид тариаланчид мэдээ, мэдээлэл гарын авлагаар хангагдана. Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилт сайжирна.	4 сард	Мал эмнэлэг, үржлийн тасаг
7	Малчин тариаланчдын зөвөлгөөн зохион байгуулах	ЕБС-ийн эко клубуудын сурагчидын дунд танин мэдэхүйн явган аялал зохион байгуулж, орчны бохирдол үүсэх гол шалтгаан түүнийг багасгах арга замын талаар мэдээлэл өгч, тэднээс гарах санал санаачилгыг дэмжин	ЕБС-ийн эко клубуудын сурагчидын дунд танин мэдэхүйн явган аялал зохион байгуулж, орчны бохирдол үүсэх гол шалтгаан түүнийг багасгах арга замын талаар мэдээлэл өгч, тэднээс гарах санал санаачилгыг дэмжин	Орчны бохирдлын хэмжээ тодорхой хувиар буурч иргэд орчны бохирдол, эрүүл ахуйн талаар мэдлэг мэдээлэлтэй болно.	III улиралд	Б.Нямчулуун Б.Баяржавхлан Э.Гансүх
8	ЕБС-ийн ЭКО клубын болон орчны талаар зохион байгуулах	ЕБС-ийн ЭКО клубын болон орчны талаар зохион байгуулах	ЕБС-ийн ЭКО клубуудын сурагчидын дунд танин мэдэхүйн явган аялал зохион байгуулж, орчны бохирдол үүсэх гол шалтгаан түүнийг багасгах арга замын талаар мэдээлэл өгч, тэднээс гарах санал санаачилгыг дэмжин	Орчны бохирдлын хэмжээ тодорхой хувиар буурч иргэд орчны бохирдол, эрүүл ахуйн талаар мэдлэг мэдээлэлтэй болно.	III улиралд	Б.Нямчулуун Б.Баяржавхлан Э.Гансүх

9	Соёлын өдөр зохион байгуулах	ажиллах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд орчны бохирдлыг бууруулах, хяналт тавих, ажилд хамтран ажиллах талаар мэдээлэл хүргэх.	Жаргалант суманд амьдрач буй ардын авьяаснууд, чөлөөт уран бүтээлчдийг оролцуулсан урлагийн тоглолт хийх Угсаатан ястан бүрийн түүх, ёс заншил, өв уламжлалыг сурталчлах Ховд хотын үүсэл, түүхэн хөгжлийн тухай эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	Шинэ залуу авьяаснууд тодорч, 9 сард УБ хотод болох соёл урлагийн арга хэмжээнд сумаа төлөөлж оролцоно өв уламжлал ёс заншил өвлөгдөж уламжлагдана Олон эрдэмтэд докторууд хүрэлцэн ирж түүхийн тухай мэдээллийг хүргэнэ. Аймаг сумын ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжинэ	Жаргалант сумын ЗДТГ Ажлын хэсэг
				05 дугаар сард	

----- 0 0 0 -----

ЖАРГАЛАНТ СУМАНД 2015 ОНД НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ ОЙ, ТЭМДЭГЛЭЛТ ӨДӨР, СПОРТ УРЛАГ, СУРГАЛТ ЗӨВӨЛГӨӨНИЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага	
1	Цагаан сарын хүндэтгэлийн арга хэмжээ	<p>арга хэмжээ</p> <p>А. ажил үйлсээрээ манлайлан тэргүүлэн ажилласан сумын 9 алдартан аваргуудын материалыг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шалгаруулах /тусгай хөтөлбөр/</p> <p>Б. Харьялалгүй ахмад настаны судалгааг гаргаж нийгэм халамж үйлчилгээний хэлтэст хүргүүлэн гарын бэлгэнд хамруулах</p> <p>В. Байгууллагаас өндөр настаны тэтгэвэрт гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх</p> <p>Г. амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой зарим өрхүүдийн хүүхдүүдэд төсөл хөтөлбөрийн байгууллага, ОУБайгууллага хувь хүмүүстэй хамтран дэмжлэг үзүүлэх</p>	<p>хүрэх түвшин</p> <p>А. Уламжлал болон хэвшиж оны шилдэг манлайлагч нарыг тодруулсан байна.</p> <p>Б. Ажиллаж байсан албан газар нь татан буугдсан дампуурсан байгууллагуудад ажиллаж байсан ахмад настангууд судалгаа үнэн зөв гарч гарын бэлгэнд хамрагдсан байна.</p> <p>В. Амьжиргааны түвшин доогуур орлоготой өрхүүдэд дэмжлэг тусалцаа хүртсэн байна.</p>	<p>01-02 дугаар сард</p> <p>01-02 дугаар сард</p> <p>01-02 дугаар сард</p>	<p>Нийгмийн бодлогын мэргэжилтэн Багийн Нийгмийн ажилтан</p> <p>Нийгмийн бодлогын мэргэжилтэн Багийн Нийгмийн ажилтан</p>
2	Сумын буянтай ээж шалгаруулах хүндэтгэлийн арга хэмжээ	<p>А. Буянтай ээж шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлж, багуудад журмыг хүргүүлэх</p> <p>Б. Журмын дагуу ирсэн ээжүүдийн материалыг засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх</p>	<p>А. Журам батлагдаж хэрэгжинэ.</p>	<p>03 дугаар сард</p>	<p>Нийгмийн бодлогын мэргэжилтэн Багийн Нийгмийн ажилтан Ажлын хэсэг</p>
3	Дэлхийн усны өдөр тэмдэглэх	<p>А. Багуудын иргэдийн дунд байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах сэтгэлзүйг нь нэмэгдүүлэх зорилгоор "Дэвжээ" тэмцээн зохион байгуулах</p>	<p>Иргэд эх байгаль дэлхий ус хайрлан хамгаалах сэтгэлзүйн нэмэгдэж Усны зүй зохисгүй хэрэглээ буурна.</p>	<p>3 дугаар сарын 22 өдөр</p>	<p>Сумын байгаль орчны тасаг, багийн Засаг дарга нар</p>
4	Наурыз баярыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	<p>А. Казак иргэдийн дунд хотын Захирагчийн нэрэмжит гар бөмбөгийн тэмцээн зохион</p>	<p>А. Уламжлал болон зохион байгуулагдаж иргэдийн оролцоо нэмэгдэнэ.</p>	<p>3 дугаар сарын 22 өдөр</p>	<p>Ажлын хэсэг</p>

	байгуулах Б.харьяалалгүй ахмад настаны судалгааг гаргаж, нийгэм халамж үйлчилгээний хэлтэст хүргүүлэн гарын бэлгэнд хамруулах	Б. судалгаа үнэн зөв гарч гарын бэлгэнд хамрагдсан байна		
5	Нийгмийн ажилтаны өдөр зохион байгуулах	А. Төрийн болон төрийн бус байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтангуудын гэр бүлийн дунд "Нэгэн дээвэр дор" танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээн зохион байгуулах Б."Сайн үйлс сэтгэлийн дэм" хүмүүнлэгийн ажил зохион байгуулах	А. Танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион байгуулагдсан байна Б. Хүмүүнлэгийн ажил зохион байгуулагдсан байна	03 дугаар сард Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ажлын хэсэг
6	Эрүүл агаар эм өдөрлөг зохион байгуулах	А.Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх асран хамгаалагч нарын дунд гар бөмбөг, танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион байгуулах Б. Эцэг эх асран хамгаалагч нарын дунд тэдэнд тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг ярилцлага зохион байгуулах В. Хишиг өдөр зохион байгуулах /ХБХ-ийг ХОИС-ийн нийгмийн ажилтаны ангийн оюутан нартай хамтран ажиллах/	А. Иргэдийн оролцоо нэмэгдсэн байна. Б. Тулгамдаж буй асуудал нь тодорхойлогдсон байна. В. Эцэг эх асран хамгаалагч нар нь зав чөлөөтэй болж өөрийн хувийн ажлаа амжуулна А. Амьдрах арга ухаанд суралцана. Б. Гэр бүлийн оролцоо идэвх нэмэгдэнэ.	05 дугаар сард Нийгмийн бодлогын мэргэжилтэн Багийн нийгмийн ажилтан нар Ажлын хэсэг
7	ОУ-ын "Гэр бүлийн баяр"ын өдрийг зохион байгуулах	А. Залуу гэр бүлийн дунд "Амьдрах арга ухаан" лекц уншуулах Б. Байгууллагын ажилчдын гэр бүлийн дунд танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион байгуулах	А. Баярын үйл ажиллагааг зохион байгуулагдсан байна. Б. Эхийн алдар I,II одонгоор шагнагдах эхчүүд одонгоо баярын өдрөөр авна.	05 дугаар сард Ажлын хэсэг
8	Эх үрсийн баяр	А.Тусгай хөтөлбөрөөр холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах Б.Эхийн алдар I,II одонгоор шагнагдах эхчүүдэд зар хүргэж хүндэтгэлийн үйл ажиллагаанд нь бүрэн хамруулах	А. Баярын үйл ажиллагааг зохион байгуулагдсан байна. Б. Эхийн алдар I,II одонгоор шагнагдах эхчүүд одонгоо баярын өдрөөр авна.	06 дугаар сард Ажлын хэсэг
9	Хотын Захирагчийн нэрэмжит	А. Ажлын хэсэг байгуулагдан ЕБС,	А. Багш нарын идэвхи,	10 дугаар сард Ажлын хэсэг



ХОВД АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 73

Ховд

Санал дэмжих тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол Улсын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Ховд аймаг Жаргалант сумын 12 жилийн III сургуулийн математикийн багш Ноосгой овогтой Баатарсүрэнг төрийн одон “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор шагнуулахаар ирүүлсэн багийн ИНХ-ын санал, тодорхойлолт, Сумын Засаг даргын саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЭНХТӨР



ХОВД АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 74

Ховд

Санал дэмжих тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол Улсын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Ховд аймгийн Жаргалант сумын Жаргалан багийн иргэн Бярзана овогтой Цэрэндашийг төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-гоор шагнуулахаар ирүүлсэн байгууллага хамт олны санал, тодорхойлолт, Сумын Засаг даргын саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЭНХТӨР



ХОВД АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 10 өдөр

Дугаар ЖС

Ховд

Санал дэмжих тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол Улсын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Ховд аймаг Жаргалант сумын Тахилт багийн иргэн Цэвээнжав овогтой Коовыг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулахаар ирүүлсэн багийн ИНХ-ын санал, тодорхойлолт, Сумын Засаг даргын саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЭНХТӨР



ХОВД АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 76


Ховд

Санал дэмжих тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол Улсын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Ховд аймгийн Жаргалант сумын Цамбагарав багийн иргэн Жалцан овогтой Хүрэлбаатарыг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулахаар ирүүлсэн багийн ИНХ-ын санал, тодорхойлолт, Сумын Засаг даргын саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЭНХТӨР



ХОВД АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 77


Ховд

Санал дэмжих тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол Улсын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Ховд аймгийн Жаргалант сумын Рашаант багийн иргэн Бярзана овогтой Баярсайханыг төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-оор шагнуулахаар ирүүлсэн багийн ИНХ-ын санал, тодорхойлолт, Сумын Засаг даргын саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЭНХТӨР